



**МОНГОЛ УДСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2026.05.01 № 10/2108

танай _____-ны № _____-т

Удирдамж хүргүүлэх тухай

“МТЗ” ТӨХК, “УБТЗ” ХНН, “ТТЗ” ХХК,
ТЗГ, “МИАТ” ТӨХК, “ИНЕГ”, ИНҮТ
ТӨХХК, “АТҮТ” ТӨҮГ, “ЗТХТ” ТӨҮГ,
ДЗ, АЗЗА НЭГТГЭЛ, АХОЗШША,
“ХХНОБ” ТӨХХК-ИЙН ДАРГА,
ЗАХИРАЛ НАРТ

Зам, тээврийн сайдын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр баталсан 26-01 дугаартай дотоод аудитын удирдамжийг хүргүүлж байна.

Аудитын ажлын хэсэг нь харьяа байгууллагуудын баримт бичигтэй газар дээр нь танилцан ажиллах тул аудитад шаардлагатай баримт бичгийг жагсаалтын дагуу урьдчилан бэлтгэж, ажлын хэсэгт бүрэн гаргаж өгч хамтран ажиллана уу.

Хавсралт 9 хуудастай.



Зам, тээврийн яам
Салбарын хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
Газрын дарга
Х.Оюунтуяа
2026.05.01 17:40



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

БАТЛАВ.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

... оны ... дугаар сарын ...

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН УДИРДАМЖ

2026 оны 04 дугаар сарын 17

Дугаар 26-01

Улаанбаатар хот

«Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үр нөлөө,
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Төрийн албан хаагчдын
сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн
биелэлт, салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогын хэрэгжилт,
хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн
хэрэгжилтэд дотоод аудит хийх тухай

1. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай, Төсвийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хяналт, үнэлгээний хорооны 2025 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого”, “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар”, Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”, Зам, тээврийн яамны санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудитын 2026 оны төлөвлөгөөг үндэслэн Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үр нөлөө, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогын хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд эрсдэлд суурилсан дотоод аудит хийж дүгнэлт өгөх, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

2. Дотоод аудитын зорилго

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үр нөлөө, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн

142633006

биелэлт, салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогын хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж дүгнэн, илэрсэн асуудал, зөрчил дутагдлыг арилгах, бууруулах, давтан гаргахгүй байх талаар арга зүйн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

3. Дотоод аудитын хамрах хүрээ

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үр нөлөө, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Зам, тээврийн яамны Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогын хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд дотоод аудитыг түүвэрлэн гүйцэтгэх бөгөөд дараах асуудлуудыг хамруулна. Үүнд:

1. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, шилэн данс хөтлөлт, Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, хүний нөөцийн хөгжлийн бодлоготой холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарт, гэрээний хэрэгжилт;
2. Яамны дотоод нэгжүүдийн болон харьяа байгууллагуудын эрсдэлийн удирдлагын 2026 оны төлөвлөгөөний хэрэгжилт;
3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт;
4. Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;
5. Хүний нөөцийн хөгжлийн бодлогын хэрэгжилт;
6. Зам, тээврийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт;
7. Өмнө хийгдсэн хяналт, дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт;
8. Бусад.

4. Дотоод аудитын хамрах хүрээний хязгаарлалт

Цаг хугацааг хэмнэх зорилгоор Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үр нөлөө, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, салбарын хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд зарим асуудлыг сэдэвчлэн, түүвэрлэсэн байдлаар гүйцэтгэх хэдий ч, учир шалтгааныг эцэслэн тогтоох зорилгоор бусад онуудын баримт материалыг татан үзэх замаар дотоод аудитын гүйцэтгэж болно.

5. Дотоод аудитын ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

С.Түмэн-Өлзий

(Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хариуцсан шинжээч, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч)

Гишүүд:

Я.Ганцэцэг

(Нэгдсэн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах шинжээч)

Д.Баярмаа

(Иргэнийн нисэхийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан шинжээч)

Б.Өлзийдэмбэрэл

(Автотээврийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан шинжээч)

О.Чимгээ

(Авто замын салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан шинжээч)

Д.Бямбадулам

(Эрсдэлийн удирдлага, дотоод аудит хариуцсан шинжээч)

Нарийн бичгийн дарга:

Л.Шинэчимэг

(Төмөр зам, далайн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан шинжээч)

6. Хэрэгжүүлэх хугацаа

2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэл

7. Дотоод аудитыг хэрэгжүүлэх гол үе шат

Д/д	Хугацаа	Гүйцэтгэх ажил, үйлчилгээний нэр
1	04 дүгээр сарын 28-ны өдөр	Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга болон харьяа байгууллагуудын удирдлагатай уулзаж удирдамж, хөтөлбөрийг танилцуулах; tumenulzii@mrt.gov.mn хаягаар эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үр нөлөө, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Төрийн албан

		хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн баримтуудыг хүлээн авах;
		Шаардлагатай баримт материалын жагсаалтыг гарган хүргүүлж, хүлээн авах;
2	04 дүгээр сарын 28-30-ны өдөр	Ирүүлсэн мэдээ, судалгаа, баримт, материалыг үзэж, эрсдэлийг үнэлэх, нэмэлт мэдээлэл, материалуудыг авч тодруулах;
3	05 дугаар сарын 04-06-ны өдөр	Ирүүлсэн мэдээ, судалгаа, баримт, материалыг үзэж, явцын тодруулга уулзалтуудыг хийх;
4	05 дугаар сарын 07-08-ны өдөр	Нэмэлт мэдээлэл, материалуудыг авч, урьдчилсан дүгнэлт гаргах;
5	05 дугаар сарын 11-15-ны өдөр	Тайлангийн төслийг бэлтгэх;
6	05 дугаар сарын 18-21-ний өдөр	Тайлангийн төслийг танилцуулах, санал, хүсэлтийг албан бичгээр хүлээн авах;
7	05 дугаар сарын 25-ны өдөр	Тайланг эцсийн байдлаар бэлтгэн гаргах.

8. Үүрэг хариуцлага

Дотоод аудитад хамрагдаж буй нэгж:

- Шаардлагатай тайлан мэдээлэл, баримт материалыг шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх;
- Шаардлагатай судалгаа, мэдээллийг хурдан шуурхай, үнэн зөв гаргаж өгөх;
- Дотоод аудитын явцад холбогдох программ хангамжид нэвтрэн шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангах;
- Дотоод аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, санал, тайлбар, хүсэлт өгөх;
- Дотоод аудитын зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэх.

Дотоод аудитын ажлын хэсэг

- Дотоод аудитын удирдамжийн хүрээнд ажиллах;
- Дотоод аудитын ажлын явцад хамрагдаж буй байгууллагын талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах;
- Дотоод аудитын тайлангийн төслийг тухайн байгууллагын холбогдох албан тушаалтанд танилцуулах, тайлбар тодруулга авах, шаардлагатай гэж үзвэл залруулга хийх;
- Дотоод аудитыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу чанартай, бие даасан байдалтай гүйцэтгэх.

9. Дотоод аудитын дүнг тайлагнах

Дотоод аудитын ажлын тайлан, дүнг Зам, тээврийн сайд болон Дотоод аудитын хороонд танилцуулан илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах акт, албан шаардлага, зөвлөмж, цаашид авах бодлогын арга хэмжээний саналыг холбогдох газар, нэгжүүдэд хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавина.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



М.БАЯРМАГНАЙ

2026 оны 04 дугаар сарын 27

ХЯНАСАН:

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА



Х.ОЮУНТУЯА

2026 оны 04 дугаар сарын 27

БОЛОВСРУУЛСАН:

СХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ



Л.ШИНЭЧИМЭГ

2026 оны 04 дугаар сарын 27

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

Захиргаа, судалгааны тасаг, Техникийн шинжлэн шалгагч П.Гэрэлчимэг

Холбоо барих утас: 7128-5099

Цахим шуудан: gerelchimeg@aaib.gov.mn